



Долоо хоног тутмын хэвлэл
2016 оны 01 дүгээр сарын 11
№ 02 /911/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

41

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

48

**Зарим шүүгчийг анхан шатны
шүүхийн Ерөнхий шүүгчийн
албан тушаалд томилох тухай**

**Засгийн газрын агентлаг,
төрийн байгууллагуудын
бүтэц, зохион байгуулалтын
талаар авах зарим арга
хэмжээний тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

27.	Зарим шүүгчийг анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 189	41
28.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 193	43
29.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 194	43

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

30.	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 490	44
31.	Засгийн газрын агентлаг, төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 501	48
32.	Жагсаалт батлах тухай	Дугаар 502	54
33.	Жагсаалт шинэчлэн батлах тухай	Дугаар 503	57

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 12 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 189

Улаанбаатар
хот

Зарим шүүгчийг анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 16, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.4, 15.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хавсралтад дурдсан нэр бүхий шүүгч нарыг анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**



Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2015 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн
189 дүгээр зарлигийн хавсралт

Нэг. Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд:

1.Доржийн Байгалмааг Архангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

2.Халамханы Мейрамбекийг Баян-Өлгий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

3.Батмөнхийн Болор-Эрдэнийг Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

4.Лхагвасүрэнгийн Дарьсүрэнг Булган аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

5.Базаррагчаагийн Наранчимэгийг Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

6.Даваагийн Уранчимэгийг Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

7.Шоовдорын Одонзулыг Завхан аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

8.Лхамжавын Мөнхцэцэгийг Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

9.Лувсангийн Эрдэнэбатыг Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд.

Хоёр. Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд:

1.Данзангийн Сарантуяаг Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

2.Ягнайжавын Туулыг Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

3.Тогоочийн Дэлгэрмааг Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

4.Сэрдамбын Насанбуяанг Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

5.Баасанжавын Эрдэнэхишигийг Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд.



Гурав. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд:

1.Гомбодоржийн Гантуяаг Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

2.Лидагийн Одбаатарыг Сэлэнгэ аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд.

Дөрөв. Сум дундын шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд:

1.Жамбалын Отгоншишигийг Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Сум дундын шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Чимэддоржийн Баттөмөрийг эгүүлэн татаж, Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Төмөрхүлэгийн Төгсбилгүүнийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 194

Улаанбаатар хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн



3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Литва Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Адъяагийн Ганбаатарыг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Литва Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нэмэхийн Батааг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 490

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 17.1.5, Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай хууль, Улсын Их Хурлын 2015 оны 103 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2012 оны 70 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох журам”-д дор дурдсан агуулгатай дараах заалт тус тус нэмсүгэй:

1/ 2 дахь хэсгийн 2.22 дахь заалт:

“2.22. Хүүхдийн мөнгө авахаар нэгээс дээш банкинд данс нээлгэх хүсэлт гаргасан нөхцөлд иргэний хамгийн сүүлд хүсэлт гаргасан банкны дансаар хүүхдийн мөнгийг олгоно.”

2/ 4 дэх хэсгийн 4.1.4, 4.1.5 дахь заалт:

“4.1.4. тухайн өрхийн амьжиргааны түвшин нь Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн 18-20 дугаар бүлэгт багтсан;

4.1.5. хөндлөнгийн этгээдийн гаргасан өргөдөл, гомдлын дагуу дахин үнэлгээ хийхэд тухайн өрхийн амьжиргааны түвшин нь энэхүү журмын 1.2-т заасныг хангаагүй.”

3/ 4 дэх хэсгийн 4.2.3, 4.2.4 дэх заалт:

“4.2.3. Өрхийн ам бүлийн 3 болон түүнээс дээш гишүүдтэй холбоотой мэдээлэлд өөрчлөлт¹ орсон;

4.2.4. Хүүхдийн мөнгө авч байгаа хүүхэдтэй өрх сум, аймаг, нийслэл хооронд шилжилт хөдөлгөөн хийсэн.”

4/ 4 дэх хэсгийн 4.4-4.6 дахь заалт:

“4.4. Хүүхдийн мөнгө олгохтой холбоотойгоор өрхийн амьжиргааны түвшинг дахин үнэлэх ажлыг Засгийн газрын 2014 оны 404 дүгээр тогтоолоор баталсан “Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журам”-ын дагуу зохион байгуулна.

4.5. Тухайн өрх энэ журмын 4.4-т заасны дагуу дахин үнэлгээнд хамрагдаж хүүхдийн мөнгө авах эрх үүссэн бол хүүхдийн мөнгө авахаар арилжааны банкинд дахин хүсэлт гаргасан тухайн сараас эхлэн олгох бөгөөд түр зогсоосон хугацааны хүүхдийн мөнгийг нөхөн олгохгүй.

4.6. Энэхүү журмын 4.2.2-4.2.4-т заасны дагуу түр зогсоосон хүүхдийн мөнгийг тухайн мэдээллийг шинэчилсний дараа үргэлжлүүлэн олгох бөгөөд түр зогсоосон хугацааны хүүхдийн мөнгийг нөхөн олгоно.

2. Мөн журмын Нэг дэх хэсгийн 1.1 дэх заалтын “0-18 насны” гэсний өмнө “Монгол Улсын” гэж, мөн хэсгийн 1.3 дахь заалтын “банкинд” гэсний ард “өөр эзэмшигч ашиглаж байгаагүй” гэж, Хоёр дахь хэсгийн 2.10 дахь заалтын “хүүхдийн” гэсний ард “регистрийн дугаар, овог, нэр, оршин суугаа хаяг” гэж, Гурав дахь хэсгийн 3.1 дэх заалтын “иргэний” гэсний ард “арилжааны банкинд” гэж, Дөрөв дэх хэсгийн 4.2.1 дэх заалтын “мэдээлэл өгөх” гэсний дараа “хүүхдийн мөнгө авахаар нэгээс дээш банкинд санаатайгаар давхар данс нээлгэх” гэж, Тав дахь хэсгийн 5.3 дахь заалтын “Нийгмийн халамжийн” гэсний дараа “болон улсын бүртгэлийн” гэж тус тус нэмсүгэй.

3. Мөн журмын дараах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ Нэг дэх хэсгийн 1.2 дахь заалт

“1.2. Хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдсан 1-17 дугаар бүлгийн өрхийн 0-18 насны хүүхэд болон энэ журмын 3.4, 3.5-д заасан хүүхэд (цаашид “хүүхэд” гэх), эсхүл түүнийг төлөөлөх хууль ёсны эрх бүхий Монгол Улсын иргэнд олгоно.”

¹ өрхөөс 3 гишүүн хасагдах, эсхүл нэмэгдэх



2/ Гурав дахь хэсгийн 3.2 дахь заалт:

“3.2. Иргэн хүүхдийн мөнгө авч байсан банкныг солих хүсэлтэй бол сонгосон арилжааны банкны ажилтанд хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргана.”

3/ Дөрөв дэх хэсгийн 4.2.2 дахь заалт:

“4.2.2. регистрийн дугаар давхардах зэрэг өөр бусад шалтгаанаар хүүхдийн мөнгө илүү олгогдсон;”

4/ Дөрөв дэх хэсгийн 4.3 дахь заалт:

“4.3. Энэхүү журмын 4.2.1-д заасны дагуу түр зогсоосон хүүхдийн мөнгийг нөхөн олгохгүй.”

4. Мөн журмын Тав дахь хэсгийн 5.1 дэх заалтын “мэдэгдээгүй” гэснийг “мэдэгдээгүйн улмаас мөн журмын 4.2.1-д заасан нөхцөл үүссэн” гэж өөрчилсүгэй.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан хүсэлт гаргасан өрхийн амьжиргааны түвшинг үнэлэх, дахин үнэлгээ хийх зардлыг тухайн орон нутгийн Нийгмийн халамжийн сангийн 2015 оны хэмнэгдэж байгаа зардлын төсвөөс хавсралтад заасны дагуу санхүүжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга нарт зөвлөсүгэй.

6. Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны үр дүнгээс шалтгаалан хүүхдийн мөнгөнд зарцуулах хөрөнгийн хэмжээ батлагдсан төсвөөс хэтрэх тохиолдолд шаардагдах хөрөнгийг Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тодотголд тусгуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Болор, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэд тус тус даалгасугай.

7. Энэ тогтоолыг 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЭРДЭНЭ



Засгийн газрын 2015 оны 490 дүгээр
тогтоолын хавсралт

**“ОРЛОГЫГ ОРЛУУЛАН ТООЦОХ АРГАЧЛАЛ”-ААР* ӨРХИЙН
АМЬЖИРГААНЫ ТҮВШИНГ ҮНЭЛЭХ, ДАХИН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫГ
ОРОН НУТГИЙН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН 2015 ОНЫ
ХЭМНЭГДЭЖ БАЙГАА ЗАРДЛААС САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСӨВ**

№	Аймаг, нийслэлийн нэр	Өрхийн тоо	Төсөв, төгрөг
1	Архангай	1,740	23,754,801
2	Баян-Өлгий	2,660	46,082,500
3	Баянхонгор	2,094	28,583,253
4	Булган	1,273	17,373,738
5	Говь-Алтай	1,826	31,636,470
6	Дорноговь	1,563	29,545,969
7	Дорнод	1,545	25,959,600
8	Дундговь	947	17,889,304
9	Завхан	2,135	36,982,170
10	Өвөрхангай	2,513	34,296,810
11	Өмнөговь	1,597	30,190,661
12	Сүхбаатар	1,271	21,352,315
13	Сэлэнгэ	2,308	31,508,325
14	Төв	2,169	29,608,151
15	Увс	2,365	40,980,668
16	Ховд	2,559	44,339,712
17	Хөвсгөл	2,269	30,969,176
18	Хэнтий	1,779	29,879,013
19	Дархан-Уул	3,129	39,423,226



20	Орхон	3,409	42,948,729
21	Говьсүмбэр	449	8,487,839
22	Улаанбаатар	47,912	352,155,798
НИЙТ ДҮН		89,512	993,948,227

Тайлбар: *Өрхийн орлогын талаарх бүрэн мэдээлэл байхгүй тохиолдолд түүнийг төлөөлж чадахуйц бусад үзүүлэлтүүдийн тусламжтайгаар амьжиргааны түвшинг үнэлэх аргыг орлогыг орлуулан тооцох арга гэнэ. Энэхүү аргачлалыг Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасны дагуу Үндэсний статистикийн хорооны дарга, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 123/165 тоот хамтарсан тушаалаар баталсан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 501

Улаанбаатар
хот

Засгийн газрын агентлаг, төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай

Төсвийн тухай хуулийн 10.1.10, Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалт, 22 дугаар зүйл, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1, 6.3, 9.1, Улсын Их Хурлын 2015 оны 100 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2014 оны 387 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн жагсаалт”-ын “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн “5. Гаалийн ерөнхий газар, 6. Татварын ерөнхий газар” гэснийг “5. Гааль, татварын ерөнхий газар” гэж, мөн хэсгийн “7. Улсын бүртгэлийн ерөнхий газар” гэснийг “6. Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар” гэж, мөн хэсгийн “8-19” гэсэн дугаарыг “7-18” гэж тус тус өөрчилж, мөн хавсралтын “Засгийн газрын тохируулагч агентлаг” гэсэн хэсгийн “2. Төрийн өмчийн хороо” гэснийг хасч, мөн хэсгийн “3-10” гэсэн дугаарыг “2-9” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Засгийн газрын агентлагийн орон тооны хязгаарыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

3. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид өөрчлөлт орсонтой холбогдуулан Засгийн газрын тохируулагч агентлаг-Төрийн өмчийн хороог татан буулгасугай.

4. Төсвөөс санхүүждэг дараах байгууллага, ажлын албыг татан буулгаж, орон тоог цомхотгон, чиг үүргийг нь холбогдох байгууллагад дор дурдсаны дагуу шилжүүлсүгэй:

1	БНХАУ-ын Тяньжины боомт дахь “Улаанбаатарын төлөөлөгчийн газар” улсын төсөвт үйлдвэрийн газрыг татан буулгаж, чиг үүргийг нь “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанид
2	Хөдөө аж ахуйн биржийн зохицуулах зөвлөлийн Ажлын албыг татан буулгаж, чиг үүргийг нь Хүнс, хөдөө аж ахуйн яаманд
3	Цэвэр агаарын сангийн Ажлын алба, Биоаюулгүй байдлыг хангах үндэсний хорооны Ажлын алба, Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны Ажлын алба, Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хорооны Ажлын алба, Химийн хорт болон аюултай бодисын асуудал хариуцсан үндэсний зөвлөлийн Ажлын албыг тус тус татан буулгаж, чиг үүргийг нь Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яаманд

5. Үндэсний хөгжлийн хүрээлэнг Стратеги судалгааны хүрээлэнд нэгтгэн өөрчлөн зохион байгуулсугай.

6. “Гэр хорооллыг орон сууцжуулах төсөл” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг-Гэр хорооллын хөгжлийн газарт нэгтгэн өөрчлөн зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүлд даалгасугай.

7. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” улсын төсөвт үйлдвэрийн газрыг аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар болгон зохион байгуулсугай.

8. Нийслэлийн дүүргүүд дэх Усан спорт сургалтын төв, Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, нийслэлийн 9 дүүрэг дэх Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг үйл ажиллагааныхаа орлогоор өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжүүлж, зөвхөн төрийн болон орон нутгийн захиалгат үйлчилгээ худалдан авах тохиолдолд шаардагдах хөрөнгийг Нийслэлийн төсвөөс санхүүжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүлд даалгасугай.



9. Олон улсын хүүхдийн “Найрамдал” төвийг 2016 оноос эхлэн үйл ажиллагааныхаа орлогоор өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжүүлж, зөвхөн төрийн захиалгат үйлчилгээ худалдан авах тохиолдолд шаардагдах хөрөнгийг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцаас санхүүжүүлж байхыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэд даалгасугай.

10. Гааль, татварын ерөнхий газар, Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар тус тус өөрчлөн зохион байгуулагдсантай холбогдуулан эдгээр агентлагийн харьяа орон нутаг дахь салбар нэгжүүдийн бүтэц, орон тоог батлагдсан төсөвтөө багтаан зохион байгуулж ажиллахыг Сангийн сайд Б.Болор, Хууль зүйн сайд Д.Дорлигжав нарт үүрэг болгосугай.

11. Засгийн газрын агентлаг болон төсвийн зарим байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт, Сангийн сайд Б.Болор, нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл, холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай:

а) өөрчлөн байгуулсан Засгийн газрын агентлаг, байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтэц, холбогдох бусад баримт бичгийг хууль тогтоомжид заасны дагуу 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн дотор шинэчлэн батлах буюу батлуулах;

б) энэ тогтоолын 7-9 дүгээр зүйлд заасны дагуу өөрчлөн зохион байгуулсан байгууллагын бизнес төлөвлөгөө, төсвийг баталж, төрийн захиалгат ажил, үйлчилгээг гэрээ байгуулан санхүүжүүлж гүйцэтгүүлэх, цаашид үйл ажиллагаанд нь хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

в) татан буугдсан байгууллага, алба, нэгжийн чиг үүргийг шилжүүлэн авсан байгууллага Иргэний хуульд заасны дагуу татан буулгах комисс байгуулж, тухайн байгууллага, алба, нэгжийн албан хэргийг архивт, үндсэн болон бусад эд хөрөнгийг хүлээн авч, бүртгэх ажлыг зохих журмын дагуу хариуцан зохион байгуулах;

г) бүтцийн өөрчлөлтөд хамрагдсан Засгийн газрын агентлаг, байгууллагын холбогдох албан хаагчдыг хууль тогтоомжид нийцүүлэн зохих орон тоо, цалингийн сан, эд хөрөнгийн хамт чиг үүрэг нь шилжиж байгаа агентлаг, байгууллагад шилжүүлэх;



д) бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн ажилтнуудад батлагдсан төсвийн хүрээнд хуульд заасны дагуу тэтгэлэг, тэтгэмж олгох;

е) төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг Сангийн яам хариуцан зохион байгуулах болсонтой холбогдуулан холбогдох журам, зааврыг шинэчлэн боловсруулж батлуулах;

ж) үндэсний хороо, зөвлөлийн ажлын албадыг татан буулгасантай холбогдуулан холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах талаар санал боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

з) бүтцийн өөрчлөлтөд хамрагдсан байгууллагын чиг үүргийг тасралтгүй, хийдэл гаргахгүй зохион байгуулах талаар шуурхай арга хэмжээ авч, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах.

12. Бүтцийн өөрчлөлттэй холбоотой шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах үүрэг бүхий комисс, ажлын хэсгийн үйл ажиллагааны төсөвт тусгагдаагүй нэмэлт зардал, татан буугдсан буюу өөрчлөн байгуулагдсан байгууллагын архив, эд хогшлыг нүүлгэн шилжүүлэхэд гарсан бусад зардлыг улсын төсвийн “бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т зориулсан эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Сангийн сайд Б.Болор, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт нарт даалгасугай.

13. “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар тогтоолын 15 дугаар хавсралтын “Нарийн бичгийн дарга-Ажлын албаны дарга” гэснийг “Нарийн бичгийн дарга-байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн” гэж, мөн тогтоолын 18 дугаар хавсралтын “Нарийн бичгийн дарга-Ажлын албаны дарга” гэснийг “Нарийн бичгийн дарга-байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн” гэж тус тус өөрчилсүгэй.

14. Засгийн газрын 2015 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор нэгтгэн зохион байгуулах хүрээлэн, төвийн жагсаалт”-ын 22 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

22	Стратеги судалгааны хүрээлэн	45	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл	Стратегийн судалгааны хүрээлэн Үндэсний хөгжлийн хүрээлэн
----	------------------------------	----	---------------------------------	--



15. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 1997 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 176 дугаар тогтоол, “Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх тухай” Засгийн газрын 1998 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 94 дүгээр тогтоол, “Төрийн өмчийн хорооны талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 1998 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн 139 дүгээр тогтоол, “Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн тухай” Засгийн газрын 2006 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 62 дугаар тогтоол, “Улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай” Засгийн газрын 2009 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 313 дугаар тогтоол, “Журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох тухай” Засгийн газрын 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 273 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, “Биржийн зохицуулах зөвлөлийн гишүүдийг томилох, дүрэм, журам батлах тухай” Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 188 дугаар тогтоолын 2 дугаар зүйл, “Улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай” Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 46 дугаар тогтоолын 1, 2 дугаар зүйл, “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг батлах тухай” Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 190 дүгээр тогтоолын 6 дугаар зүйл, “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 387 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, “Төрийн өмчийн хорооны гишүүдийг томилох тухай” Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 1 дүгээр тогтоол, Засгийн газрын 2015 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор нэгтгэн зохион байгуулах хүрээлэн, төвийн жагсаалт”-ын 23 дахь заалт, “Төсвийн байгууллагуудад хийх бүтэц, зохион байгуулалтын зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 55 дугаар тогтоолын 10 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

16. Энэ тогтоолыг 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

С.БАЯРЦОГТ

САНГИЙН САЙД

Б.БОЛОР



Засгийн газрын 2015 оны 501 дүгээр
тогтоолын хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН
ОРОН ТООНЫ ХЯЗГААР**

№	Агентлагийн нэр	Орон тоо
1	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар	37
2	Хөрөнгө оруулалтын газар	30
3	Онцгой байдлын ерөнхий газар	105
4	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	129
5	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	36
6	Стандартчилал, хэмжил зүйн газар	123
7	Худалдан авах ажиллагааны газар	55
8	Оюуны өмчийн газар	31
9	Цаг уур, орчны шинжилгээний газар	54
10	Гааль, татварын ерөнхий газар	184
11	Цагдаагийн ерөнхий газар	298
12	Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар	253
13	Архивын ерөнхий газар	82
14	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	101
15	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар	130
16	Тахарын ерөнхий газар	135
17	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар	62
18	Иргэний нисэхийн ерөнхий газар	106
19	Ашигт малтмалын газар	137
20	Газрын тосны газар	109
21	Мал эмнэлэг, үржлийн газар	21
22	Нийгмийн даатгалын ерөнхий газар	72
23	Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар	48
24	Хүүхдийн төлөө үндэсний газар	35



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 502

Улаанбаатар
хот

Жагсаалт батлах тухай

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүний жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Шинээр үйлдвэрлэсэн ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүнийг энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан жагсаалтад оруулах, жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг хасах асуудлыг тухай бүр Засгийн газарт оруулж шийдвэрлүүлж байхыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Сангийн сайд Б.Болор нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 286 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

САНГИЙН САЙД

Б.БОЛОР

УУЛ УУРХАЙН САЙД

Р.ЖИГЖИД

Засгийн газрын 2015 оны 502 дугаар
тогтоолын хавсралт

АШИГТ МАЛТМАЛЫН ЭЦСИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ

№	Код	Бүтээгдэхүүний нэр	Тайлбар
1	2612.10.00	Ураны баяжмал	Шар кейк (ураны хүдрийг баяжуулан гаргаж авсан шар нунтаг)
2	2613.10.20	Молибдений улайсган боловсруулсан баяжмал	Молибдений баяжмалыг боловсруулах замаар гаргаж авсан бүтээгдэхүүн (чанаржуулсан гангийн найрлагад ордог)



3	2825.70.00	Молибдений исэл	Молибдений баяжмалыг боловсруулах замаар гаргаж авсан бүтээгдэхүүн (чанаржуулсан гангийн найрлагад ордог)
4		Баяжуулсан нүүрс	Хуурай болон нойтон аргаар технологийн боловсруулалт хийсэн нүүрс
	2701.11.21	Антрацит	Дэгдэмхий $V^{daf} < 8$, Үнслэг $A^d < 12$, Илчлэг $Q^{ar} > 7000$
	2701.11.22	Хагас антрацит	Дэгдэмхий $V^{daf} < 14$, Үнслэг $A^d < 15$, Илчлэг $Q^{ar} > 6500$
	2701.12.21	Коксжих	Барьцалдах чанар $G_i \geq 60$, Дэгдэмхий $V^{daf} < 28$, Үнслэг $A^d \leq 10.5$, $10.5 < 12$, ≥ 12
	2701.12.22	Сул коксжих	Барьцалдах чанар $G_i \geq 60$, Дэгдэмхий $V^{daf} > 28$, Үнслэг $A^d \leq 10.5$, $10.5 < 12$, ≥ 12
	2701.12.23	Коксжих чанаргүй нүүрс	Барьцалдах чанар $G_i < 60$, Илчлэг $Q^{ar}_{net} > 5000$, ≥ 4500 , Нийт чийг $W^l < 12$, Үнслэг $A^d \leq 20$, ≥ 20
5	2701.20.00	Чулуун нүүрснээс гаргаж авсан брикет, шахмал нүүрс болон эдгээртэй төстэй хатуу түлш	-
6	2704.00.10	Чулуун нүүрсний кокс болон хагас кокс	-
7	2704.00.20	Хүрэн нүүрсний кокс болон хагас кокс	-
8	2706.00.00	Нүүрсний давирхай	Кокс үйлдвэрлэхэд гардаг дайвар бүтээгдэхүүн (химийн үйлдвэрт хэрэглэдэг)



9	2805.30.00	Газрын ховор металлын баяжмал	Газрын ховор элемент агуулсан хүдрийг баяжуулан гаргаж авсан болон химийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүн. Бүтээгдэхүүн дэх газрын ховор элементүүд болон тэдгээрийн ислийн нийлбэр агуулга нь хүдрийн гарал үүсэл, эрдсүүдийн шинж чанар, агуулгаас хамааран 60 хувиас багагүй байх
10	7901.11.00	Хольцгүй цайр	Жингийн 99.99 хувьд цайр агуулсан байх
11	7203.10.00	Төмрийн хүдрийг шууд ангижруулах замаар гаргаж авсан төмөрлөг бүтээгдэхүүн	Баяжуулсан хүдрээс гаргаж авсан хорголжин болон тэдгээртэй адил төст хэлбэртэй бүтээгдэхүүн (80 хувиас дээш металл төмрийн агуулгатай байх)
12	7106.92.00	Хайлж цэвэршүүлсэн мөнгө	999 сорьцтой байх
13	7403.11.00	Катодын зэс	-
14	7601.10.00	Хольцгүй хөнгөн цагаан	-
15	8001.10.00	Хольцгүй цагаан тугалга	-
16	2529.21.20	Хайлуур жоншны баяжмал (фторт кальцийн агууламж 95 хувь буюу түүнээс дээш)	2529.21.20 кодоод хамаарах жоншны баяжмалуудаас фторт кальцийн агууламж нь 97-95 хувьтай бүтээгдэхүүнийг ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүний жагсаалтад хамруулах бөгөөд 95 хувиас доош агууламжтай бүтээгдэхүүн нь 2529.21.20 кодоод хамаардаг боловч энэ жагсаалтад орохгүй
	2529.22.20		
17	78.04	Хольцгүй хар тугалга	-

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 503

Улаанбаатар
хот

Жагсаалт шинэчлэн батлах тухай

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.1.9, 13.2, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.6, 38.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нэмэгдсэн өртгийн албан татвар болон гаалийн албан татвараас чөлөөлөх хийн түлш, хийн түлшний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоноглолын жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Жагсаалт шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2011 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 297 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

САНГИЙН САЙД

Б.БОЛОР

Засгийн газрын 2015 оны 503 дугаар
тогтоолын хавсралт

ХИЙН ТҮЛШ, ХИЙН ТҮЛШНИЙ САВ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН МАШИН, ТЕХНИК ХЭРЭГСЭЛ, ТОНОГЛОЛЫН ЖАГСААЛТ

№	Код	Барааны нэр, төрөл
А.Хийн түлш		
1	2705.00.00	Нийлэг хий (Synthetic gas – SG)
2	2711.11.00	Шингэрүүлсэн байгалийн хий: метан (Liquefied natural gas-LNG)
3	2711.12.00	Шингэрүүлсэн пропан: пропан, бутаны холимог (пропаны агууламж > бутаны агууламж) (Liquefied petroleum gas- LPG)
4	2711.13.00	Шингэрүүлсэн бутан: пропан, бутаны холимог (пропаны агууламж <бутаны агууламж) (Liquefied petroleum gas- LPG)



5	2711.21.00	Хийн байдалтай байгалийн хий:метан (Natural gas-NG)
6	2909.19.00	Диметилийн эфир (Di methyl ether-DME)
7	2901.10.00	95 хувь, түүнээс дээш хувийн цэвэршилттэй бутан (C4H10) (Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 148 дугаар тогтоолоор нэмсэн)
Б. Хийн түлшний хангамж, хэрэглээний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоноглол		
8	3917.31.00	Хуванцар уян хоолой: Хийн түлш дамжуулах уян хоолой; хүчилтөрөгчөөр даралт өгөх хоолой; автоцистерн болон вагон-цистернээс хийг буулгах, ачих зориулалтын цагирган хоолой
9	40.09	Хаймар хоолой: Хийн түлш дамжуулах уян хоолой; хүчилтөрөгчөөр даралт өгөх хоолой; автоцистерн болон вагон-цистернээс хийг буулгах, ачих зориулалтын цагирган хоолой
10	4016.99.00	Хийн баллоны хамгаалалтын уян бүслүүр
11	7304.11.00	Хийгээр хангах, хий гадагшлуулах холболтын төмөр буюу ган хоолой, криоген хоолой
12	73.07	Хийн хоолой, резервуарын зориулалттай дэрвэн (фланц); хийн шугам хоолойн шилжүүлэгч ган холбоос, тахир холбоос, хийн хоолойн ган холбогч
13	7308.90.00	Галын аюулаас хамгаалах хана: Хийн тоног төхөөрөмжийн бэхлэгээний хэрэгсэл, хамгаалах тусгаарлах самбар, анкер боолт
14	7309.00.00	Усан шалгалтын ган сав: бойлерийг усаар хангах ган резервуар
15	7311.00.00	Хий хадгалах сав, резервуар, баллон, танк (хамтдаа нийлүүлэгдсэн тоног хэрэгсэл орно)
16	7318.15.00	Боолт (хийн тоног төхөөрөмжийн)
17	7318.16.00	Эрэг (хийн тоног төхөөрөмжийн)
18	7321.11.00	Хийн түлшээр ажилладаг ахуйн зориулалтын зуух, ус халаагч төхөөрөмж
19	7321.81.00	Хийн түлшээр ажилладаг ахуйн зориулалттай хатаах төхөөрөмж, халаагуур
20	7321.90.00	Хийн түлшээр ажилладаг зуух, шарах шүүгээ, түүний ширэм, ширэмний тор
21	7326.90.00	Хий дамжуулах хоолой болон хадгалах савны тулгуур: газардуулгын нуман ган холбоос, хий хамгаалах таг



22	7411.10.00	Зэс хоолой, зэс сифон хоолой (хий дамжуулах)
23	7411.21.00	Хийн баллоныг холбох гуулин хоолой
24	7412.10.00	Зэс цагирган холбогч: газардуулгын нуман зэс холбоос (хий дамжуулах хоолойн)
25	7608.10.00	Хөнгөн цагаанаар хийсэн утааны яндан хоолой
26	7616.99.00	Хийн баллоны бэхэлгээний хөнгөн цагаан гинж
27	83.07	Үндсэн материалаар хийсэн уян хоолой: Хийн түлш дамжуулах уян хоолой; даралт өгөх хоолой; автоцистерн болон вагон-цистернээс хийг буулгах, ачих зориулалтын цагирган хоолой, хий цэнэглэх станцын цахилгаан шугам хамгаалах бүрхэвч хоолой
28	8403.10.00	Дулааны болон үйлдвэрлэлийн халаалтын зориулалттай хийн түлшээр ажилладаг ус халаах бойлер
29	8405.10.00	Хийн түлшний генератор
30	8409.91.00	Автотээврийн хэрэгслийн хий холигч төхөөрөмж
31	8411.81.00	Хийн түлшний турбин (хүчин чадал нь 5000 кВт-аас ихгүй)
32	8411.82.00	Хийн түлшний турбин (хүчин чадал нь 5000 кВт-аас их)
33	8413.11.00	Автомашиньг хийн түлшээр цэнэглэх төхөөрөмж
34	8413.19.00	Баллонд хий савлах, хийгээр цэнэглэх насос; баллоныг хийгээр цэнэглэх тоног төхөөрөмж (баллоны цэнэгийг шалгах эргэх дүүжин маягийн төхөөрөмжийн хамт)
35	8413.81.00	Хийн түлшний насос
36	8413.82.00	Вагон-цистерн, автоцистерн, баллоноос шингэрүүлсэн хий юүлэх төхөөрөмж
37	8413.91.00	Автоцистернийг хийн түлшээр цэнэглэх хошуу; хийн түлшний насосны эд анги; конденсат цуглуулагч; конденсат зайлуулагч; түгээгүүрийн цэнэглэх хоолойн аюулгүйн холбогч; ахуйн зориулалттай баллон цэнэглэх хошуу
38	8414.10.00	Вакуум насос, хий сорох төхөөрөмж
39	8414.40.00	Хийн түлшний болон агаарын, дугуйт шасси дээр суурилуулсан компрессор
40	8414.51.00	Хий ашигладаг барилга байгууламжийн салхилуур (125 Вт-аас ихгүй хүчин чадалтай)



41	8414.59.00	Хий ашигладаг барилга байгууламжийн салхилуур (125 Вт буюу түүнээс дээш хүчин чадалтай)
42	8414.80.00	Агаар нөөцлөгч
43	8416.20.00	Усны бойлерыг халаах зориулалтын хийн түлш шатаагч хэсэг
44	8418.29.00	Хийн түлшээр ажилладаг ахуйн зориулалттай хөргөгч
45	8418.69.00	Хийн дээж хадгалах хөргөгч
46	8419.39.00	Хийн баллоны будгийн хатаалгын камер
47	8419.60.00	Хийг шингэрүүлэх машин, төхөөрөмж
48	8419.89.00	Хий ууршуулагч
49	8419.90.00	Ууршуулагчийн мембран
50	8421.29.00	Тос, ус тусгаарлагч
51	8421.39.00	Хий шүүх, цэвэрлэх төхөөрөмж
52	8421.99.00	Хий шүүх төхөөрөмжийн шүүлтүүр
53	8422.20.00	Хийн баллоныг уураар угаах, цэвэрлэх, хатаах, хийгүйжүүлэх төхөөрөмж
54	8423.82.00	Баллоныг хийгээр дүүргэсний дараа жинлэх ба хэмжээг зохицуулагч автомат төхөөрөмж
55	8423.89.00	Автоцистерн жинлэх төхөөрөмж (авто пүү)
56	8424.20.00	Хийн баллон будах шугам, камер
57	8424.89.00	Галыг автоматаар унтраах бороожуулагч
58	8425.49.00	Вагон-цистернээс хийн түлшийг буулгах, ачих дамжуурга, түүний тоноглол
59	8426.19.00	Баллон зөөх кран
60	84.27	Баллонтой хий зөөх үйлдвэрийн зориулалттай авто-ачигч, авто-тэргэнцэр
61	8428.33.00	Хийн баллон зөөвөрлөх туузан конвейер
62	8428.39.00	Гинжит зөөвөрлөгч
63	8468.20.00	Хийн түлшээр ажилладаг гагнуурын аппарат
64	8472.90.00	Баллонтой хийн түлшинд баталгаажуулалтын тэмдэг тавих төхөөрөмж
65	8479.89.00	Хийн түлш хуваарилах төхөөрөмж; хийн тоног төхөөрөмжийг засварлах, суурилуулах, тохируулга хийх тусгай зориулалтын багаж хэрэгсэл



66	84.81	Хийн автоцистерн, резервуар, баллон зэрэг савны зориулалттай хавхлага, хаалт, даралт сааруулагч хавхлага; хийн хавхлагуудыг хаах зориулалттай хяналтын товчлууран самбар; хавхлага шилжүүлэх төхөөрөмж
67	8484.10.00	Металл жийргэвч
68	8484.20.00	Тоног төхөөрөмжийг холбох, угсрах зориулалтын механик жийргэвч
69	8502.39.00	Хийн түлшээр ажиллах цахилгаан үүсгүүр
70	8523.40.00	Технологийн хяналтын программ хангамж бүхий компакт диск
71	8531.80.00	Хийн алдагдлыг мэдээлэх ахуйн зориулалтын дохиоллын аппарат, дохиоллын гэрэл; шингэрүүлсэн хийн тэсрэх найрлагын хэмжээг автоматаар мэдээлэх дохиоллын багаж
72	8606.10.00	Хийн түлш тээвэрлэх вагон-цистерн
73	8609.00.00	Хийн түлш тээвэрлэх чингэлэг-цистерн
74	8704.21.00	Баллонтой болон чингэлэгт хий тээвэрлэх тусгай зориулалтын ачааны машин (бүх жин ≤ 5 тонн, дизель хөдөлгүүртэй)
75	8704.31.00	Баллонтой болон чингэлэгт хий тээвэрлэх тусгай зориулалтын ачааны машин (бүх жин ≤ 5 тонн, бензин хөдөлгүүртэй)
76	8704.90.00	Баллонтой болон чингэлэгт хий тээвэрлэх тусгай зориулалтын ачааны машин (хийн түлшээр ажилладаг хөдөлгүүртэй)
77	8704.90.00	Хийн түлш тээвэрлэх, цэнэглэх автоцистерн (5 тонн $<$ бүх жин ≤ 20 тонн)
78	8708.99.00	Автомашинд суурилуулах хийн түлшний баллон, дамжуулах хоолой, холигч, даралт тохируулагч, хөдөлгүүрийн удирдлага, түлшний төрлийг шилжүүлэх товчлуур, хий хуваарилалтыг хянах төрөөрөмж
79	8716.31.00	Цистерн-чиргүүл, хагас чиргүүл
80	9024.10.00	Баллоны даралт тэсвэржилтийг шалгах төхөөрөмж
81	90.25	Термометр
82	9026.10.00	Шингэрүүлсэн хийн түвшин, урсгал хэмжих багаж
83	9026.20.00	Манометр (хийн даралт хэмжих багаж)
84	9026.80.00	Хийн түвшин, урсгал хэмжих багаж



85	9026.90.00	Хийн шугам хоолойн хяналтын шил; хийн даралт хэмжигчийн суурь
86	9027.10.00	Хий шинжлэх багаж, хий мэдрэгч, хийн нягтыг тодорхойлох хэмжих багаж
87	9027.20.00	Хроматографын багаж
88	9027.80.00	Хийн шугам хоолойн болон баллоны гэмтэл, битүүмжлэл, хийн алдагдлыг тодорхойлох багаж
89	9027.90.00	Хий шинжлэх багажийн шүүлтүүр; хийн дээж бэлтгэгч
90	9028.10.00	Хийн тоолуур; хийн зарцуулалтын индикатор
91	9028.90.00	Хийн тоолуурын холбогч
92	9032.10.00	Термостат (дулаан хянах, тохируулах багаж)
93	9032.20.00	Маностат (даралт хянах, тохируулах багаж)
94	9032.81.00	Хийн урсгал тохируулагч
95	9032.89.00	Электрон удирдлагатай систем
96	9405.50.00	Хийн түлшээр ажилладаг дэнлүү
В. Хийн хайгуул, олборлолтын техник, төхөөрөмж, хэрэгсэл (gas exploration, gas production, coring rigs and ancillary equipment)		
97	8431.43.00	Дээжийн баррель (Core barrels)
98	8421.39.00	Ангжруулагч канистр (Desorption canisters)
99	8419.89.00	Температур хэмжигч ванн (Temperature baths)
100	8431.43.00	Хийн дээж авах багаж (Gas sampling equipment)
101	9026.20.00	Өрмийн хошуу шалгагч багаж (Drill stem testing equipment)
102	8431.43.00	Дээж авах тусгай хэсгүүд (Specialty coring bits)
103	9027.80.00	Каротажийн судалгааны багаж (Wire line logging tools)
104	9015.80.00	Акустик дүрс буулгагч (Acoustic scanners)
105	7304.22.00	Дээж авах өрмийн штанг -PQ, HQ (Coring rods PQ, HQ)
	7304.23.00	
	7305.20.00	
	7306.21.00	
106	8479.89.00	Цооногийн доод хэсгийн багаж (Down hole equipment)
107	8421.39.00	Каротажийн судалгаа хийхэд ашиглагддаг геофизикийн төхөөрөмж олсоор гүйлгэгч багаж (Wire line stripper)
108	8431.43.00	Нээлттэй өрмийн штанг ба хэсгүүд (Open hole rods and bits)
109	8431.43.00	Тэнцвэржүүлэгчид ба өрмийн амсар (Stabilizers and drill collars)



110	8481.80.00	Нөөцийн хавхлага, цооногийн тэсрэлтээс хамгаалагч (Stabbing valves, Kelly cock)
111	8481.30.00	Үл буцагч хавхлага (Non return valve)
112	8479.89.00	Гэнэтийн их хэмжээний хий цооногоос гарах үед тэсрэлтээс сэргийлэх хамгаалагч (Annular bag blow out preventer)
113	8481.10.00	Хувиргагч, чиглэл өөрчлөгч (Diverters)
114	8479.89.00	Сэгсрэгч шигшүүр (Shaker and demander)
115	8413.50.00	2 талт, 3 талт насос (Duplex and triplex pumps)
116	7304.24.00	Хайрцаглагч (Casing)
	7304.29.00	
	7305.20.00	
	7306.21.00	
7306.29.00		
117	8430.49.00	Үйлдвэрлэлийн өрөм (Production rigs)
118	8479.89.00	Цооногийн толгой (Well head)
119	7304.11.00	Цооногийн дамжуулах хоолой (Well pipelines)
	7304.19.00	
	7305.11.00	
	7305.12.00	
	7305.19.00	
	7306.11.00	
7306.19.00		
120	8419.89.00	Ууршуулах хэсгийн шугам татах (Lining for evaporation plants)
121	9027.80.00	Усны дээж авах багаж (Water sampling equipment)
122	9026.20.00	Өрмийн хошуу туршигч багаж (Drill stem testing equipment)
123	9015.80.00	“Веллдог”-ийн төхөөрөмж (Well dog equipment)
124	7304.22.00	Үйлдвэрлэлийн турба (Production tubing)
	7304.23.00	
	7304.29.00	
	7305.20.00	
	7306.21.00	
	7306.29.00	
7304.22.00		
125	7304.23.00	Үйлдвэрлэлийн хайрцаг (Production casing)
	7304.29.00	
	7305.20.00	
	7306.21.00	
	7306.29.00	
126	8431.50.00	Газрын гүний насос (Sub surface pump)
127	8430.49.00	Газрын гүнд өрөмдлөгийг өргөсгөх багаж (Under-reaming equipment)



128	85.01	Генератор-хөдөлгүүр (Generators)
129	8479.89.00	Нүүрсний давхаргын метан хийн тэсрэлтээс хамгаалагч (Coal bed methane blow out preventers)
130	8430.69.00	Өрмийн өндөрсгөсөн платформ (Elevated rig platform)
131	8479.89.00	Кооми 3-5000 писиай (Koomey 3-5000 psi)
132	7307.99.00	Хаалт (Choke)
133	8481.80.00	Хий шатаах шугам (Flare lines, Hammer unions est)
134	8479.90.00	Тэсрэлтээс сэргийлэгч дамар (Blow out preventer - BOP spool)
135	8479.89.00	Өргөн цооногийн толгой (Broaden well head)
136	8481.80.00	Цооногийн нүхийг цементэлж хайрцаглахад ашиглагддаг бөглөө (Bump plugs)
137	8479.10.00	Цементлэх хэсэг (Cementing unit)
138	9026.80.00	Туршилтын насос ба хэмжигч багаж (Test pump and gauges)
139	8430.41.00	Өөрчлөн засах өрөм (Work over rigs)
140	8430.49.00	Хагарал эрчимжүүлэх, дэмжих, нэмэгдүүлэх (Fracture stimulation equipment)
141	8421.29.00	Даралтын аргаар шүүгч багаж (Reverse osmosis equipment)
142	8421.19.00	Тусгаарлагчид (Separators)
143	8413.50.00	Шавран насос (Mud pump)
144	85.02	Генераторын систем (Gen sets)
145	90.15	Гидрогеологийн судалгааны багаж (Hydro geological studies equipment)
146	8414.80.00	Компрессор (Compressors)
147	8414.40.00	Компрессор-дугуйт эд ангид суурилуулсан (Compressors-when mounted on a wheeled chassis)
148	8481.80.00	Ус дамжуулах хоолойн хавхлага ба хэсгүүд (Flow-valves and checks)
149	8421.29.00	Хий дамжуулах хоолойгоор ирж байгаа их хэмжээний хийг хадгалах хэсэг (Slug catchers)

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1,5

Индекс: 14003